БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2020/134/СТА-ТШЗ**


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com
Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2020 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Агуулга


Аудитын гэрчилгээ ............ 3

Аудитын тайлан ............ 5

**2.1.** Оршил ............ 5

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ............ 5

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт** ............ 5

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин** ............ 5

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ............ 6

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ............ 6

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ............ 6

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ............ 7

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ............ 8

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ............ 8

2.13. Шилэн дансны мэдээлэл ............ 8

Шилэн дансны цахим санд "Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар" /улирал бүр/ байршуулах мэдээллийг 1,3-р улиралд, "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар" /тухай бүр/ мэдээллийг 1,2,4-р сард, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл /тухай бүр/ мэдээллийг 1,3-9-р сард, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг /тухай бүр/ мэдээллийг 1-9 сард хугацаа хоцроон мэдээлсэн байна. ............ 9

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт** ............ 9

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл** ............ 9

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан ............ 10

**1.1** Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан ............ 10

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ............ 11

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан ............ 12

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ............ 14

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ............ 14

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ............ 16




005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2020.08.20 № 11/138

танай ____________ -ны №____________ -т

ӨЛЗИЙТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА А.СҮХЭЭ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 12-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлзийт сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020076



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**2.1. Оршил**

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч А.Сүхээ танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

**2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 13–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Өлзийт сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн анхан шатны болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэн, хувь хүн хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад” оршино.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Өлзийт сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгэм эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
- Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ
- Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих гэрийн сувилахуй, сэргээн засах, өдрийн эмчилгээ, оншилгоо эмчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Өлзийт сумын ЭМТ-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өлзийт сумын ЭМТ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Өлзийт сумын ЭМТ-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Өлзийт сумын ЭМТ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 312957,9 мянган төгрөгөөс тооцон 6259,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 442115,9 мянган төгрөгөөр тооцон 8842,3 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17128.66 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 30,310.65 | 33,207.81 | 2,897.16 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 30,308.70 | 33,207.81 | 2,899.11 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 485,374.71 | 465,348.89 | -20,025.82 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 485,374.71 | 465,348.89 | -20,025.82 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | 126,162.50 | 147,968.11 | 21,805.61 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 515,685.35 | 498,556.70 | -17,128.66 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 515,673.48 | 498,556.70 | -17,116.78 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 515,673.48 | 498,556.70 | -17,116.78 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 515,685.35 | 498,556.70 | -17,128.66 |

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 2899.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь “Монс фрам” ХХК-аас дох, тэмбү өвчний тест хандиваар үнэ төлбөргүй 3096,0 мянга төгрөг, иргэн Д.Дулмаагаас хүнсний ногоо 42,5 мянган төгрөгийн бараа материал орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1779,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба энэ нь 2019 онд төсвийн хөрөнгөөр 12970,0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан харин 11190,2 мянган төгрөгийн балансын үнэтэй үндсэн хөрөнгийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 129 дугаар тогтоолыг үндэслэн актлан данс бүртгэлээс хассан байна. Тайлант онд 31323,4 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон ба хуримтлагдсан элэгдлийн дүн 147968,1 мянган төгрөг байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 498556,6 мянган төгрөг болж 17116,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн хасах илэрхийлэгдсэнтэй холбоотой байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Өлзийт сумын ЭМТ нь төвлөрүүлэх орлого байхгүй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрт зориулан 80101 /үндсэн үйл ажиллагаа/, 81603 /мэргэжлийн тусламж үйлчилгээ/, 80101 /тогтмол зардал/, 80302 /нэг иргэнд ноогдох нормативаар/-д зориулалттай 428460,2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Нийт зардлын 363231,9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 26763,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, Эрүүл мэндийн даатгалын сангаас 31795,9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Тайлант онд улсын төсвөөс авах 421791.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, харин ЭМДС-гаас 38465,1 мянган төгрөгийн төсөв батлагдснаас 31765,9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж 6669,1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 421650,1 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь улсын төсвөөс 421650,1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулж 6810,0 мянган төгрөг хэмнэгдэн төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

**Нэмэлт төсөв:** Сорьц тээврийн зардал 34,8 мянган төгрөг аймгийн Эрүүл мэндийн газраас нэмэлт санхүүжилтийн дансанд орж ирсэн нь олгогдсон байна.

### 2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 35 эрсдэлийг үнэлж гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт 25 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2352,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов.

1. Цалингийн зардлаас ажилтнуудад ЭМТ-ын даргын 2019.12.18-ны өдрийн Б/71 тоот тушаалаар 2352,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил” гэсэн төсвийн зарлагын ангиллаас гаргасан, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>**Шийдвэрлэсэн нь:**</u> Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 2352,0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож 2020 оны 04 дүгээр сарын 25-ны дотор төсөвт төвлөрүүлэх.

### 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

### 2.13. Шилэн дансны мэдээлэл

Өлзийт сумын ЭМТ-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 1 | 3 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 87 | 9 | |
| | Нийт | 27 | 151 | 137 | 12 | 2 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шилэн дансны цахим санд:

- "Тухай жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /тухай бүр/ байршуулах мэдээллийг 5-8 сар мөн 12 сард,
- "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, шийдвэрийн хуулбар" /тухай бүр/ мэдээллийг 11-р сард,
- Байгууллагын батлагдсан төсөв /бүтэн жил/ мэдээллийг 1-р сард,
- Бонд, зээл өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр /тухай бүр/ мэдээллийг 3,11,12-р сард хугацаа хоцроон мэдээлсэн байна.

**2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

**2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Өлзийт сумын ЭМТ-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

### 1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,310,645.40** | **33,207,807.61** |
| **33** | **АВЛАГА** | 1,949.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,949.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 30,308,696.40 | 33,207,807.61 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,760,708.80 | 5,827,557.80 |
| 35130 | Эм боох материал | 1,760,708.80 | 5,827,557.80 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,547,987.60 | 27,380,249.81 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,023,860.00 | 699,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,657,134.00 | 14,679,209.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 823,000.00 | 1,053,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 33,380.00 | 485,994.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 810,800.00 | 429,300.00 |
| 35460 | Хүнсний материал | 343,300.51 | 149,460.51 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,856,513.09 | 9,883,486.30 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **485,374,709.41** | **465,348,892.14** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 485,374,709.41 | 465,348,892.14 |
| **392** | **Биет хөрөнгө** | 478,710,709.41 | 458,684,892.14 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 448,031,700.00 | 448,031,700.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -19,894,584.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 36,150,000.00 | 34,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,040,833.45 | -23,108,333.51 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 104,681,238.45 | 99,388,337.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -95,836,631.20 | -91,910,670.57 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,360,274.40 | 23,982,974.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -11,635,038.79 | -12,404,531.51 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 6,664,000.00 | 6,664,000.00 |
| 39301 | Програм хангамж | 650,000.00 | 650,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -650,000.00 | -650,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 6,664,000.00 | 6,664,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **515,685,354.81** | **498,556,699.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **11,873.72** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 11,873.72 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 11,873.72 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 8,411.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,462.72 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **515,673,481.09** | **498,556,699.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 515,673,481.09 | 498,556,699.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 198,108,353.00 | 198,108,353.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 198,108,353.00 | 198,108,353.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -140,081,731.04 | -157,198,512.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -140,081,731.04 | -140,081,731.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -17,116,781.34 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 457,646,859.13 | 457,646,859.13 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **515,685,354.81** | **498,556,699.75** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **377,225,496.00** | **424,999,180.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **481,900.00** | **3,173,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 481,900.00 | 3,173,300.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 481,900.00 | 3,173,300.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 34,800.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 481,900.00 | 3,138,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **42,051,296.00** | **58,593,980.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 334,692,300.00 | 363,231,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,275,136.00 | 34,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,275,136.00 | 34,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 26,763,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 26,763,200.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7,776,160.00 | 31,795,980.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,776,160.00 | 00.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 31,795,980.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **395,299,380.98** | **440,443,619.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **395,299,380.98** | **440,443,619.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 357,188,587.98 | 440,267,896.66 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,128,422.00 | 268,606,833.00 |
| 210101 | Үндсэн цалин | 157,245,622.00 | 195,512,133.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,233,600.00 | 57,675,400.00 |
| 210104 | Урамшуулал | 16,649,200.00 | 15,419,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,821,200.00 | 33,582,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,290,919.26 | 22,996,461.45 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,165,101.45 | 2,542,359.73 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,732,080.96 | 2,156,499.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 421,190.67 | 512,993.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,211,907.66 | 5,374,586.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,814,429.00 | 23,672,493.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,291,549.00 | 1,487,993.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,438,880.00 | 21,818,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 84,000.00 | 365,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,474,955.15 | 25,895,090.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,599,889.00 | 2,099,060.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,787,420.02 | 13,044,031.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 685,933.72 | 820,898.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 242,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,606,426.00 | 7,426,075.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,795,286.41 | 2,263,026.75 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,085,544.00 | 34,333,744.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 21,206,104.00 | 27,197,404.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,823,440.00 | 7,136,340.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 56,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,818,100.00 | 381,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,818,100.00 | 381,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 772,000.00 | 981,000.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 772,000.00 | 981,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 655,235.00 | 434,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 172,500.00 | 34,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 482,735.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40,618,702.83 | 52,379,535.91 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,496,565.00 | 21,056,060.04 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,096,250.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 20,025,887.83 | 31,323,475.87 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 38,110,793.00 | 175,723.28 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,094,767.00 | 00.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,744,631.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,350,136.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,026.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,026.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 90,707.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 90,707.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 85,016.28 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 85,016.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-18,073,884.98** | **-15,444,439.94** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,503,636.79 | 1,672,341.40 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 800,799.91 | 1,672,341.40 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 702,836.88 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,503,636.79 | -1,672,341.40 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-19,577,521.77** | **-17,116,781.34** |

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **376,743,596.00** | **421,874,939.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **34,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 34,800.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 34,800.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 34,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **376,743,596.00** | **421,840,139.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 334,692,300.00 | 363,231,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,275,136.00 | 34,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 34,275,136.00 | 34,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 26,763,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 26,763,200.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7,776,160.00 | 31,810,239.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7,776,160.00 | 14,259.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 31,795,980.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **376,743,596.00** | **421,874,939.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **376,743,596.00** | **421,874,939.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **338,601,274.00** | **421,684,956.72** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 215,090,431.00 | 268,613,295.00 |
| 210101 | Үндсэн цалин | 157,207,631.00 | 195,518,595.00 |
| 210102 | Нэмэгдэл | 41,233,600.00 | 57,675,400.00 |
| 210104 | Урамшуулал | 16,649,200.00 | 15,419,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,821,200.00 | 33,582,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,227,000.00 | 22,196,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,148,600.00 | 2,846,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,718,800.00 | 2,277,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 429,700.00 | 569,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,297,100.00 | 5,693,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,814,429.00 | 23,672,493.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,264,213.00 | 1,487,993.00 |
| 210302 | Түлш, халаалт | 21,466,216.00 | 21,818,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 84,000.00 | 365,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,815,633.00 | 17,065,155.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,455,700.00 | 1,775,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,247,733.00 | 12,396,686.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 712,800.00 | 904,319.72 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,399,400.00 | 1,989,150.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,212,504.00 | 38,083,753.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 19,197,504.00 | 28,168,253.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,000,000.00 | 6,900,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,015,000.00 | 3,015,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,198,900.00 | 16,982,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,600,000.00 | 9,842,500.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 4,140,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,598,900.00 | 3,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 772,000.00 | 981,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 772,000.00 | 981,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,461,400.00 | 434,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,925,000.00 | 34,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 400,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 536,400.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,414,777.00 | 22,269,060.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,418,527.00 | 22,269,060.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,996,250.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,142,322.00** | **189,982.28** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,126,296.00 | 14,259.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7,776,160.00 | 14,259.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 30,350,136.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 16,026.00 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,026.00 | 00.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 90,707.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 90,707.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 85,016.28 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 85,016.28 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-140,081,731.04** | 515,673,481.09 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-140,081,731.04** | 515,673,481.09 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-140,081,731.04** | 515,673,481.09 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -17,116,781.34 | -17,116,781.34 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **198,108,353.00** | **457,646,859.13** | **-157,198,512.38** | 498,556,699.75 |

### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 428,460,200.00 | 421,650,156.72 | 6,810,043.28 | 98.41 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 428,460,200.00 | 421,650,156.72 | 6,810,043.28 | 98.41 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 428,460,200.00 | 421,650,156.72 | 6,810,043.28 | 98.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 268,663,000.00 | 268,613,295.00 | 49,705.00 | 99.98 |
| 210101 | Үндсэн цалин | 195,568,300.00 | 195,518,595.00 | 49,705.00 | 99.97 |
| 210102 | Нэмэгдэл | 57,675,400.00 | 57,675,400.00 | 0.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 15,419,300.00 | 15,419,300.00 | 0.00 | 100.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,582,900.00 | 33,582,900.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,196,400.00 | 22,196,400.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,846,600.00 | 2,846,600.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,277,300.00 | 2,277,300.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 569,300.00 | 569,300.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,693,300.00 | 5,693,300.00 | 0.00 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,763,200.00 | 23,672,493.00 | 90,707.00 | 99.62 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,544,500.00 | 1,487,993.00 | 56,507.00 | 96.34 |
| 210302 | Түлш, халаалт | 21,818,700.00 | 21,818,700.00 | 0.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 365,800.00 | 34,200.00 | 91.45 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,027,500.00 | 17,065,155.72 | 3,962,344.28 | 81.16 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,775,000.00 | 1,775,000.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,303,800.00 | 12,396,686.00 | 3,907,114.00 | 76.04 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 948,700.00 | 904,319.72 | 44,380.28 | 95.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,000,000.00 | 1,989,150.00 | 10,850.00 | 99.46 |
| **2105** | **Нормативт зардал** | 40,269,100.00 | 38,083,753.00 | 2,185,347.00 | 94.57 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,353,600.00 | 28,168,253.00 | 2,185,347.00 | 92.80 |
| 210502 | Хоол, хүнс | 6,900,000.00 | 6,900,000.00 | 0.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,015,500.00 | 3,015,500.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,985,000.00 | 16,982,500.00 | 2,500.00 | 99.99 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,845,000.00 | 9,842,500.00 | 2,500.00 | 99.97 |
| 210602 | Тавилга | 4,140,000.00 | 4,140,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,500,000.00 | 981,000.00 | 519,000.00 | 65.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,500,000.00 | 981,000.00 | 519,000.00 | 65.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 400,000.00 | 400,000.00 | 0.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22269500.00 | 22269060.00 | 440.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,269,500.00 | 22,269,060.00 | 440.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 428,460,200.00 | 421,650,156.72 | 6,810,043.28 | 98.41 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 363,231,900.00 | 363,181,683.72 | 50,216.28 | 99.99 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 363,231,900.00 | 363,181,683.72 | 50,216.28 | 99.99 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 26,763,200.00 | 26,672,493.00 | 90,707.00 | 99.66 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 26,763,200.00 | 26,672,493.00 | 90,707.00 | 99.66 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 38,465,100.00 | 31,795,980.00 | 6,669,120.00 | 82.66 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 38,465,100.00 | 31,795,980.00 | 6,669,120.00 | 82.66 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 0.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилта | 20.00 | 20.00 | 0.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 05.00 | 05.00 | 0.00 | 100.00 |

### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 34800.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 34,800.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **34,800.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | | 34,800.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 34800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 34,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 34,800.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

6417143544
БЮА0067 9007423



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ